

## “МОНГОЛ ДАХЬ МЭДЭЭЛЛИЙН ЭРХ ЧӨЛӨӨ” СУДАЛГААНЫ ТАЙЛАН

|   |    |
|---|----|
| I. Өмнөх үг   | 2  |
| II. Бүлэг 1: Мэдээлэл авах эрх чөлөө ба хэвлэл мэдээллийн чөлөөт байдал   | 3  |
| - Хүнд суртал   | 4  |
| - Хэвлэл мэдээллийн албад   | 5  |
| - Байгууллагын болон бусад нууц   | 5  |
| - Цагдаа, шүүх, прокурор Хамгийн хаалттай байгууллага   | 7  |
| - Сэтгүүлчдийн мэдээлэл авах эрхийг хуульчлах хэрэгтэй юу?  | 10 |
| - Мэдээлэл авах олон арга бий...  | 11 |
| - Ёс зүй бай хэвлэлийн эрх чөлөө  | 13 |
| - Сэтгүүлчдийг хамгаалах бамбай   | 16 |
| - Хэвлэлийн эрх чөлөөнд аюул учраад байна уу?   | 18 |
| - Сэтгүүлчдээ бид өмөөрөх хэрэггүй, гэхдээ ...  | 19 |
| - Сэтгүүлч, шүүх, цагдаа  | 22 |
| - Хэвлэлийн эрх чөлөөний төлөө тэмцэл хүнд бөгөөд хэцүү, зарим талдаа нэлээн ужиг удаан байх болно ...  | 24 |
| III. Бүлэг 2: Сэтгүүлч бичсэн нийтлэлийнхээ төлөө Шүүхийн шийдвэр сонсож ял хүлээсэн хэргийн тохиолдлоос ...  |    |
| - Case I; “Монголын нэг өдөр” сонины сурвалжлагч А.Эрдэнэтуяагийн “Д.Мөрөн гишүүний охин Камертоны Болдын ахын үхэлд буруутнаар тодрохдоо эцгийнхээ нэрийг тас нуужээ” нийтлэлтэй холбоотой хэргийн тохиолдол | 28 |
| - Case II; “Сэрүүлэг” сонины ерөнхий редактор Б.Цоожчулуунцэцэгийн “М.Моёор: Улсын нөөцийн мөнгөөр гараа угаасан хүмүүс намайг унагах гэж оролдож байна” гэсэн ярилцлагатай холбоотой хэргийн тохиолдол       | 34 |
| IV. Хавсралт  |    |
| - Судалгаанд оролцож ярилцлага өгсөн сэтгүүлч, мэргэжилтнүүдийн нэрс  |    |
| - Судалгааг хэрэгжүүлсэн багийн гишүүд  |    |

## ӨМНӨХ ҮГ

“Үг” сонины эрхлэгч Ханддолгорыг өөрийнх нь эрхэлдэг сонинд гарсан нийтлэлийн төлөө шоронд хорьсон дуулиант хэргийг уншигч Та санаж буй биз. Сэтгүүлчид, хэвлэл мэдээллийн шинжээчид, улс төрчид энэ хэргийг өөр өөрсдийн үзэл бодлын үүднээс дүгнэн хэлцэж, нэг хэсэг нь Ханддолгорыг буруушааж, нөгөө хэсэг нь эсэргүүцэж, хэвлэлийн эрх чөлөөнд ноцтой халдаж байна хэмээн дүгнэж байсан. Үүнээс хойш ахиад нэг сэтгүүлч эмэгтэй бичсэн зүйлийнхээ төлөө эрүүгийн хуулийн дагуу хариуцлага хүлээж, энэ талаарх сэтгүүлчид, шинжээчид, олон нийтийн санаа бодол мөн л хуваагдаж байв.

2004 оны 5 сард Хэвлэлийн Хүрээлэнгээс орон даяар явуулсан олон нийтийн санал асуулгын дүнгээр, судалгаанд оролцогчдын дийлэнх нь буюу 44 хувь нь Монголд **мэдээллийн эрх чөлөө** бүрэн хангагдсан хэмээн үзэж байв. Иргэд үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл авах, түгээх эрх чөлөөгөө эдлэхэд **хэвлэл мэдээллийн чөлөөт байдал** чухал ач холбогдолтой байдаг. Харин мэдээллийн эрх чөлөөг баталгаажуулж өгдөг хэвлэлийн эрх чөлөө тийм ч хангалттай хэрэгжихгүй байна гэж олон сэтгүүлч үздэг аж.

*“Гадны нүдээр харахад эрх чөлөө хангалттай байгаа. Хэрвээ хэвлэлийн эрх чөлөөг 100 хувь гэж үзвэл бодит байдалд 10 хувь нь л байна. Эрх чөлөөний 90 хувийг бид санхүүгийн дутагдлаас болж алдаж байна”*

- Өдрийн сонины сурвалжлагч Алтантуяа

*“Манайд хэвлэлийн эрх чөлөө хагас хаалттай л байна. Хуулиар зохицуулдаггүй, мэдээлэл авах боломжгүй. Мэдээлэл авах, түгээх боломж нь хаагдаж байхад энэ эрх чөлөөг ямар эрх чөлөө гэдэг юм бэ?”*

- 25-р суваг ТВ-ийн мэдээллийн албаны дарга Баатархуяг

*“Бидэнд эрх чөлөө хангалттай байна шүү дээ. Бид харин байгаа юмаа эдэлж, өөд нь татаж цэгцлээд ахиад дээшээ явах ёстой”*

- Монголын Үндэсний Радиогийн Хурд Агентлагийн сурвалжлагч Эрдэнэчимэг.

Сэтгүүлч Эрдэнэчимэгийн нэгэн адил, “Бидэнд хангалттай эрх чөлөө байна” хэмээн үзэж буй сэтгүүлч цөөнгүй байгаа боловч, хэвлэл мэдээллийн эрх чөлөө бүрэн хэрэгжихгүй байна гэж дүгнэх сэтгүүлч ч нэлээдгүй байна. Хэний харъяалалд, ямар хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллаж байгаагаас шалтгаалаад, сэтгүүлчдийн ажиллах нөхцөл, мэдээлэл авах болон түгээх орчин ялгаатай байдаг. Тэр хэмжээгээрээ хэвлэлийн эрх чөлөөний байдлыг өөр өөрсдийн байр сууринаас харж, дүгнэдэг аж. Энэхүү байдлыг Ардчилал сонины сэтгүүлч Цэрэн-Очир “Магтах, сайшаах үед хэвлэлийн эрх чөлөө нээлттэй. Болохгүй бүтэхгүй байгаа байдлын тухай мэдээлэлд, тухайлбал ядуурал, ажилгүйдэл, авилгал гэх мэтэд эрх

чөлөө хаалттай байна. Сэтгүүлчид өөрсдөө 2 хуваагдсан. Нэг хэсэг нь албан тушаалтнуудад үйлчилдэг, нөгөө хэсэг нь шүүмжилдэг. Нэг нь хар гэхэд нөгөө нь улаан гээд дунд нь ард түмэнд учрыг ойлгохгүй хоцроод, итгэх итгэлгүй болдог” хэмээн тодорхойлж байв. Хэн нэгнээс хараат байж, аль нэг талыг барьж туйлширдаг байдал нь хэвлэлд итгэх итгэл үнэмшлийг бууруулж, сэтгүүлчдийн нэр хүндийг унагаснаар эргээд тэдний ажилд саад болж байгааг ойлгож, ийм байж болохгүй хэмээн дүгнэх сэтгүүлч ч цөөнгүй байх аж.

Монголын хэвлэл мэдээллийн эрх чөлөөт байдал нийгэм эдийн засаг, улс төр, хууль эрх зүйн орчноос шалтгаалаад зогсохгүй сэтгүүлчдийн үзэл санаа, мэргэжлийн ур чадвар, мэдлэг боловсролтой салшгүй холбоотой. Энэхүү эмхэтгэл Монгол Улсад Үндсэн хуулиар хамгаалагдсан үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөө хэрхэн хэрэгжиж буйг толилуулахыг зорьсон юм. Ингэхдээ мэдээллийн эрх чөлөөний тулгуур болох хэвлэл мэдээллийн чөлөөт байдлыг сэтгүүлчдийн нүдээр харж, дүгнэхийг хичээлээ. Энэхүү эмхэтгэл Таныг хэвлэл мэдээллийн янз бүрийн байгууллагад ажиллаж буй сэтгүүлчид, тэдний хөдөлмөр, ажиллаж буй орчин, үзэл бодолтой танилцуулж, монголын хэвлэл мэдээллийн байдлын талаар өөрийн дүгнэлт хийхэд тань тус болно хэмээн итгэж байна.

## БҮЛЭГ 1

### **МЭДЭЭЛЭЛ АВАХ ЭРХ ЧӨЛӨӨ БА ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЛИЙН ЧӨЛӨӨТ БАЙДАЛ**

Мэдээлэл авах эрх чөлөө болон хэвлэлийн эрх чөлөө нь нэг зоосны хоёр тал, мэдээлэл авах эрх хэрэгжихгүйгээр, хэвлэл мэдээлэл эрх чөлөөтэй байна гэж үгүй.

Монгол Улсын Үндсэн Хуулийн хоёрдугаар бүлгийн арван долдугаар зүйлд заасны дагуу, Монгол Улсын иргэн “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй”.

Мэдээлэл авах эрх, тэр тусмаа төр, засгийн байгууллагын үйл ажиллагааны тухай мэдээлэл авах боломж нээлттэй байх нь ардчилсан тогтолцооны нэгэн чухал шалгуур. Төр, засгийн байгууллагын үйл ажиллагааны тухай олон түмэнд мэдээлэх нь нэг талаас хариуцлага, нөгөө талаас итгэл үнэмшил бий болгоход тулгуур үүрэг гүйцэтгэнэ. Мэдээлэлгүйгээр олон түмний хяналт тогтоох, хариуцлага тооцох боломж үгүй. Мэдээлэлгүйгээр төр засагт итгэл үнэмшил бий болгох, улмаар улс төр, нийгмийн амьдралд оролцох иргэдийн оролцоог дэмжин дэлгэрүүлэх боломжгүй. Мэдээлэлгүйгээр ардчилсан нийгмийг бүтээн босгох боломжгүй.

Глоб Интернэшнл ТББ-ын тэргүүн Х.Наранжаргал иргэдийн мэдээлэл авах эрхийн ач холбогдлыг онцолж, “Монгол Улсын Үндсэн хуулийн 3-р зүйлд Монгол Улсын

засгийн бүх эрх ард түмний гарт байна, ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцох эрхтэй гээд заачихсан байгаа. Тэгэхээр шууд оролцооныхоо эрхийг хэрэгжүүлэхийн тулд ерөөсөө л мэдээлэлтэй байх шаардлагатай. НҮБ-ын анхдугаар ассемблейн 59-р тогтоолд мэдээллийн эрх чөлөө бол хүний язгуур эрх, энэ бол хүний бусад бүх эрхийн үндсэн хэмжүүр мөн гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл хүний бусад эрх, нийгэм, соёл, улс төрийн бүх эрхийг хэрэгжүүлэх гол үндэс нь мэдээлэл байдаг учраас энэ бол гол хэмжүүр нь. Мэдээллийн эрх чөлөө байхгүй бол бусад эрх хэрэгжих тухай ярилтгүй” хэмээн ярьсан юм.

Мэдээллийг олон түмэнд түгээх, олон түмний санаа бодлыг төр засагт хүргэх чухал үүргийг сэтгүүлчид гүйцэтгэдэг. Харин сэтгүүлчид мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх бодит боломжтой байж гэмээнэ нийгмийн өмнө хүлээх энэхүү хариуцлагаа биелүүлэх боломжтой. Тиймээс мэдээлэл авах эрх чөлөө болон хэвлэлийн эрх чөлөө нь нэг зоосны хоёр тал, мэдээлэл авах эрх хэрэгжихгүйгээр, хэвлэл мэдээлэл эрх чөлөөтэй байна гэж үгүй.

Энэхүү эмхэтгэлийг бэлтгэх явцад бид “Өнөөдөр”, “Өдрийн сонин”, “Үнэн”, “Сэрүүлэг”, 25-р суваг ТВ, Монголын Үндэсний телевиз, ММ агентлаг зэрэг янз бүрийн харъяалал бүхий төрөл бүрийн хэвлэл мэдээллийн байгууллагад ажиллаж буй сэтгүүлчидтэй уулзаж, тэдний ажил үүргээ биелүүлэх явцад гардаг хүндрэл бэрхшээлийн талаар ярилцсан юм. “Төр, олон нийтийн байгууллагууд мэдээлэл өгдөггүй” хэмээн бидний уулзсан сэтгүүлчид бараг нэгэн дуугаар ярьцгааж байв.

### **Хүнд суртал**

“Үнэндээ төрийн байгууллагууд ганцхан тохиолдлоос бусдад нь хойрго ханддаг. Тэр ганц тохиолдол нь юу гэвэл тухайн байгууллагыг сурталчлах, магтах явдал. Үүнээс бусад тохиолдолд шууд татгалзахгүй ч гэсэн асуудлыг аль болох хойш тавьж, “одоо хүн нь байхгүй байна”, “дараа ирээрэй”, “тэр мэднэ” гэх зэргээр албан бус саад гаргадаг. Хэрвээ шууд хариулт авах гэвэл уурлаж уцаарлах бол энхүүхэнд. Тэр ч байтугай “үүнийг мэдэж яах гээд байгаа юм”, “би заавал хэлэх албатай юм уу” гэж төвөгшөөдөг” хэмээн өдрийн сонины сурвалжлагч, Хэвлэлийн Хүрээлэнгийн нэрэмжит 2003 оны шилдэг сэтгүүлч өргөмжлөлийн эзэн Алтантуяа ярьсан юм. Үүнтэй олон сэтгүүлч санал нийлж байв. “Би мэдэхгүй, тэр хүнээс ав гээд өдөржин явуулдаг. Энэ бол мэдээлэл өгөхгүй гэсэн санаа, арга хэлбэр л байх. Цагаар шахагдаж байгаа сэтгүүлчид өдөртөө багтаж материалаа өгөх ёстой байдаг, гэтэл тийм хариу өгдөг” хэмээн 25-р суваг телевизийн мэдээллийн албаны дарга Баатархуяг ярьж байсан. Гадаадын сэтгүүлчдэд ч ийм бэрхшээл байнга тохиолддог аж. Монголд 17 жил ажиллаж, амьдарч буй Ройтерс агентлагийн сурвалжлагч Иръя Халаш “Жишээ нь Иракт явсан Монгол цэргийн зардал хэдэн төгрөг байгааг мэдэх гэж олон газраар олон хоног явсан. Мэдээлэл авч чадаагүй л байна. Сангийн яам үүнийг улсын нууц гэдэг. Өөр ямар ч байгууллага дээр очсон мэдээлэл авахад хэцүү. Би мэдэхгүй, тэр хүн мэднэ. Тэр хүн дээр нь очихоор

байдаггүй, эсвэл бас өөр хүний нэр хэлж өгдөг. Ингээд хичнээн ч хоног явж болно...” хэмээн санаа алдсан юм.

Төрийн байгууллагуудын хүнд суртал сэтгүүлчдэд хамгийн том хүндрэл учруулдаг. Үүний зэрэгцээ, Иръя Халашийн ярьсанчлан, “Ер нь ямар мэдээлэл өгч болох эсэх талаар ямар нэгэн системтэй ойлголт байдаггүй. Бага шатны дарга нар нэг юм хэлдэг, дунд шатныхан өөр юм хэлнэ. Дээд дарга нар нь бүр өөр юм ярина. Нэг газраас мэдээлэл авч болдоггүй ч, тэр мэдээллийг өөр газраас авч болдог...”

### **Хэвлэл мэдээллийн албад**

Монголд сүүлийн жилүүдэд төрийн ихэнх байгууллагууд хэвлэлийн төлөөлөгчтэй болсон нь сэтгүүлчдэд мөн нэлээд хүндрэл учруулдаг аж. “Аль нэг яаман дээр очлоо гэхэд тэр нь хэвлэл мэдээллийн албатай, тэр нь бөөн хүнд суртал. Тэр хэвлэлийн төлөөлөгчөөр нь дамжуулж цаг авна, үйлээ үзэж байж цаг аваад очихоор өгөх мэдээллээ урьдаас бэлдчихсэн, ядуурал буурсан, ажилгүйдэл багассан, манай байгууллага сайн ажиллаж байгаа гэнэ. Өөр мэдээлэл өгөхгүй” хэмээн сэтгүүлч Цэрэн-Очир бухимдана. “Өнөөдөр” сонины сурвалжлагч Д.Заяабат “Үнэн хэрэгтээ Хэвлэл мэдээллийн албад нь сэтгүүлчдийн хүссэн буюу тэдэнд шаардлагатай мэдээллийг өгч чадахгүй байна. Тэд ямар ч эрх мэдэлгүй, удирдлагын өгснийг л дамжуулах, аль болох магтах, хамгаалах хандлагатай. ХМА байгуулсан нэрээр төрийн захиргааны түшмэд мэдээлэл өгөхөөс татгалзаж, хүнд суртал гаргаж байна” гэхэд “Өдрийн сонин”-ы сурвалжлагч Алтантуяа “Хэвлэлийн төлөөлөгчид нь тэрнээс асуу, тийм дарга л мэднэ гэх мэтээр зөвхөн зохицуулах үүрэг л гүйцэтгэдэг” хэмээн санал нийлж байв. Гэхдээ бүх сэтгүүлчид ийн боддоггүй, учир нь төрийн харъяа мэдээллийн хэрэгсэл, тухайлбал ММ агентлаг, Монголын Үндэсний Телевиз болон Монголын Радиогийн сурвалжлагчид ийм бэрхшээл тохиолддоггүй аж. ММ агентлагийн сурвалжлагч Отгонбаатарын хувьд, “Төр засгийн мэдээллийн агентлаг гэдгээрээ ч юм уу, төрийн байгууллагаас мэдээлэл авахад нэг их саад гардаггүй. Урьд нь би Ийгл телевизэд ажиллаж байсан. Тухайн үед энэ телевизийг сөрөг хүчний байр суурьтай хэмээн эмээж, эрх барьж байсан хүмүүс Ийгл телевизэд хаалттай байдаг байсан. Тэр үед хүндрэл гарах тохиолдолд камераа асаагаад шууд дайрч орох арга хэрэглэдэг байсан бол ММ агентлагт орсноос хойш тийм тохиолдол гараагүй” гэв. Монголын Үндэсний Радиогийн Хурд агентлагийн сурвалжлагч Эрдэнэчимэг мөн адил “өөрийнхөө байгууллагын нэрийг бариад очиход хүмүүс сайн хүлээж авдаг. Хүндрэл гардаггүй. 1998 онд сургуулиа төгсөөд л радиод ажиллаж эхэлсэн, өнгөрсөн 8 жилд тийм бэрхшээл гарч байсныг санахгүй байна ” гэлээ. Гэхдээ энэ нь нэг талаар “төрийн” гэсэн статустай холбоотой ч, нөгөө талаар бас Монголын радиогийн итгэл үнэмшил, мэргэжлийн түвшинтэй ч холбоотой байдаг аж. “Монголын радио худлаа ярьдаггүй гэдэг утгаараа хүмүүс мэдээлэл өгөх дуртай байдаг.

## **Байгууллагын болон бусад нууц**

Байгууллагын нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1-р хэсэгт “Байгууллага нь нууцаа хамгаалах журмыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн өөрөө тогтоож мөрдөнө” хэмээн заасан байдаг.

Глоб Интернэшнл ТББ байгууллагын нууцын хуультай холбоотойгоор төрийн захиргааны 48 байгууллагад судалгаа хийж үзэхэд, тухайн байгууллагын нууцынх нь жагсаалт нь өөрөө нууц байдаг 32 байгууллага байсан аж. “Бодитой мэдээллийг олж авч чадахгүй байгаа нь сэтгүүлчид олон нийтийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхэд яах аргагүй саад тотгор болж байгаа юм” хэмээн Х.Наранжаргал дүгнэж байна.

Ер нь байгууллагын нууцын тухай журам гаргаж, мөрддөг, ямар мэдээллийг тухайн байгууллагын нууцад хамруулах тухай ойлгомжтой, тодорхой мэдээлэл өгдөг байгууллага тун ховор. Сэтгүүлчдийн ярьж буйгаар, ийм журам байдаггүй учир мэдээлэл өгөхийг хүсээгүй тохиолдолд “Байгууллагын нууц” хэмээн сэтгүүлчдийн амыг таглах нь олонтаа тохиолддог аж. “Үнэн” сонины орлогч эрхлэгч Бүдээхүү, хэвлэл мэдээллийн салбарт ажиллаад 6 жил болж байна. Тэрээр “Байгууллага өөрийнхөө нууцын тухай журам тогтоох ёстой байдаг. Гэтэл тэр нь тодорхой биш, олон зүйлийг хамруулдаг учир сэтгүүлчдэд мэдээлэл авахад хаалт болж байна” гэсэн юм.

Мэдээлэл авах эрхийг хааж буй тодорхой бус хуулийн заалтаас гадна төрийн албан хаагч эрхэлж буй ажил хэргийнхээ талаар мэдээлэл өгөхийг шууд хязгаарласан дүрэм ч байдаг аж. 1999 онд Засгийн Газрын Тогтоолоор баталсан Төрийн захиргааны албан тушаалтны ёс зүйн дүрмийн 1.3-т “Удирдлагаас өгсөн үүрэг, даалгавар, чиглэлийн дагуу эрхэлж буй ажил үүргийнхээ хүрээнд Засгийн Газраас явуулж буй бодлого, түүний хэрэгжилт, тухайн байгууллагаас хийж буй ажил, хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр тайлбар хийж болох боловч албан ёсны аливаа мэдээллийг эрх бүхий албан тушаалтны зөвшөөрөлгүйгээр тарааж дэлгэрүүлэхийг цээрлэнэ” гэж заажээ. Сэтгүүлчдийн ярьж буйгаар, энэхүү дүрмийг төрийн албан хаагчид ягштал биелүүлдэг аж. “Энгийн мэдээллийг ганцхан хүн мэддэг. Бусад нь бүгд айдаг. Төрийн өөрийн өмчийн хороо гэхэд хамгийн дээд дарга нь л мэднэ. Гадаад харилцааны яам мөн адил. Асуудлыг шууд хариуцсан хүн “Би хариулж болохгүй. Хэвлэл мэдээллийн хэлтсийн даргаас асуу” гэдэг. Тэр нь “тэр хүнтэй ярилцлага хийх гэж яах нь вэ? Ямар учиртай юм бэ?” гээд, миний ажлыг надаас илүү мэдэх гээд байдаг” хэмээн Иръя Халаш ярьсан.

Төрийн байгууллага, албан тушаалтнуудад мэдээлэл өгөхийг хориглосон, хязгаарласан хууль дүрэм нь хүнд суртлыг өөгшүүлж, олон түмний эрх ашигт үйлчлэх үүрэг бүхий сэтгүүлчид наад захын мэдээлэл авахад ч саад болж байгаа аж. Нөгөө талаар, эдгээр хууль дүрэм нь хэвлэлийн эрх чөлөөний хуульд харшилж, мэдээллийн эрх чөлөөнд сөргөөр нөлөөлдөг аж. Хатагтай Наранжаргалын ярьж

буйгаар, Глоб Интернэшнл ТББ 2002 он хүртэлх хугацаанд гарсан хуулиудыг судалж үзэхэд, 232 хуулиас 91 нь мэдээллийн эрх чөлөөтэй холбоотой байсан, эдгээрээс 51 нь хэвлэлийн эрх чөлөөний хуультай ямар нэгэн байдлаар зөрчилдөж байсан аж.

“Статистик мэдээллийг хүртэл авахад хүндрэлтэй болсон. Ийм мэдээлэл авах гээд очиход хаанаас явж байна, ямар зорилготой юм, яах гэж байгаа юм, хэн гэдэг хүн бэ гэх мэтээр асууж байцаадаг “ хэмээн чөлөөт сэтгүүлч Б.Цондовдорж ярьсан. Мөн Өдрийн сонины сурвалжлагч Алтантуяа “Үүнээс гадна санхүүгийн тайлан тооцоотой холбоотой мэдээллийг авахад маш хүндрэлтэй. Тухайлбал, төслийн хэдэн төгрөг нь бичиг цаасанд, хэдэн төгрөг нь мод суулгахад зарцуулсан бэ гэх мэт. Өөр нэг зүйл бол, өнгөрсөн үеийн тухай мэдээлэл авахад маш хэцүү. Сүүлийн үед байгууллагууд архивгүй болсон юм уу, ажил хариуцаж байгаа хүмүүс нь “би энэ ажлыг саяхан авсан, сайн мэдэхгүй байна” гээд л ам тагладаг. Жишээ нь 35 тендерийн баримтаас 25 нь алга болсон гэх мэдээллийн дагуу сурвалжилсан боловч нотлох баримт олдохгүй байсан. Боловсон хүчний тогтвор суурьшил муу, хүмүүс ажил хүлээж авахдаа их хайнга ханддаг болсон юм уу, эсвэл зориудаар байгаа хүнийг нь сольчихдог юм уу, бүү мэд.”

Энэ байдал нь нэг талыг барьж тэнцвэртэй мэдээлдэггүй, албан бус мэдээ, цуурхал тараадаг гэх мэт сэтгүүлчдийн нэр хүндэд муугаар нөлөөлдөг аж. 25-р суваг телевизэд ажиллаж буй сэтгүүлч Баатархуяг “ Жишээ нь бид валютын ханшийн тухай мэдээлэл хийхэд валютын арилжааны цэгүүдээр явж мэдээлэл авч байна, валютын ченжүүдтэй уулзаж яриа авч байна. Яагаад унаж байгааг нь тайлбарлаж байна. Гэтэл яг Монгол банкнаас ороод асуухад “25-р суваг уу? Мэдээлэл өгөхгүй ээ” гэж байгаа юм. Ингэхлээр дутуу, өрөөсгөл мэдээлэл болж байгаа биз дээ. Гэтэл бид бүрэн мэдээлэл авахыг оролдоогүй биш, оролдсон” хэмээн тайлбарлана.

ХБНГУ-д төрийн албан хаагчид хүссэн мэдээллээ байгууллагын нууцад хамруулах боломжгүй бөгөөд, мэдээлэл өгөхийг ямарваа нэгэн хуулийн үндэслэлгүйгээр татгалзсан тохиолдолд хуулийн хариуцлага хүлээдэг. Учир нь тэд зөвхөн Үндсэн хуулиар хамгаалагдсан бусад эрх зөрчигдөх магадлалтай байх тохиолдолд тухайн мэдээллийг нууцад хамруулах эрхтэй байдаг. /U. Branahl, Medienrecht, 2.Auflage, 1997, Westdeutscher Verlag GmbH, Opladen, p.39/

АНУ-д нууцлалд хамааруулж болох мэдээллийн төрлийг Мэдээллийн эрх чөлөөний хуулиар тодорхойлсон байдаг. Үүнд үндэсний аюулгүй байдалтай холбоотой, захиргааны материал, байгууллагын нууцын журмын дагуу нууцлалд хамрагдах материал, хувь хүнээс авсан санхүү, бизнесийн холбогдолтой мэдээлэл, төрийн байгууллага, агентлаг хоорондын ажлын явцын албан бичиг, төрийн байгууллагын боловсон хүчний хувийн материал, эрүүл мэндтэй холбоотой бичиг баримт, хууль хэрэгжүүлэх зорилгоор ашиглаж буй мэдээлэл /шүүх, цагдаа, прокурор гэх мэт/, банк санхүүгийн байгууллагын итгэл үнэмшилтэй холбоотой санхүүгийн мэдээлэл, төрийн байгууллагын эзэмшиж буй геолог, хайгуулын мэдээлэл зэрэг ордог.



## **Цагдаа, шүүх, прокурор Хамгийн хаалттай байгууллага**

Дашрамд дурдахад, хууль хяналтын байгууллага, цагдаа, шүүх, прокурор, мөн эмнэлгийн байгууллагуудаас мэдээлэл авах хамгийн хүнд гэдгийг бидний уулзсан сэтгүүлчид бүгд баталсан юм. “Жишээ нь би эрүүгийн цагдаагийн газар очиж мэдээлэл авъя гэхэд тэр хүн надтай уулзана. Гэхдээ өнөөдөр эрүүгийн цагдаагийн байгууллагын 70 жилийн ой болж байгаа тухай, Эрүүгийн цагдаагийн газар хичнээн сайн ажиллаж, олон хэрэг илрүүлж байгаа тухай ярихаас биш өнөөдрийн илрэхгүй байгаа хэрэг яагаад илрэхгүй байгаа тухай, хэргийн ахиц ямар шатандаа яваа талаар мэдээлэл өгдөггүй” хэмээн “Сэрүүлэг” сонины ерөнхий редактор Цоожчулуунцэцэг яриу. Үүнтэй олон сэтгүүлч санал нийлж байсан. Тухайлбал, Өнөөдөр сонины сурвалжлагч Заяабатын яриагаар, “Цагдаа, тагнуул, шүүх, прокурорынхон дарга мэднэ, эсвэл тодорхой мэдээлэл өгөхөөс татгалзаж байна гэж хариулдаг. Хэвлэл мэдээллийн албаныхан мэдээлэл дутуу, бидний шаардлагыг хангадаггүй, өнгөрч хуучирсан, ач холбогдлоо алдсан, өөрөө огт мэдэхгүй үйл явдлын тухай мэдээлэл өгдөг” аж.

Бидний шар хэмээн нэрлэж заншсан чөлөөт хэвлэлд дээр дурдсан байгууллагууд бүр ч дургүй гэнэ. “Бидэнд өгөхгүй гэсэн мэдээллээ өөр сонингуудад өгчихсөн, нүүр нүүрээр нь материал гаргачихсан л байдаг. Бид өчнөөн сар жил явж явж авч чадаагүй мэдээлэл маргаашийнх нь аль нэг сонинд дээр гарчихсан л байдаг. Яаж ялгаварлаж хандаад байгааг нь бас л анхаарч үзэх ёстой” /”Монголын нэг өдөр”, Отгонцэцэг/

Цагдаагийн Ерөнхий Газрын хэвлэл мэдээллийн албаны дарга, хурандаа Билгээд сэтгүүлчдийн энэхүү хандлагын талаар ярьж, тайлбар хүсэхэд тэрээр “Цагдаагийн байгууллага чинь нарийн дүрэмтэй байдаг. Бүх мэдээллийг ЦЕГ-аас тогтоосон нэгдсэн журмаар, эндээс өгдөг. Гэмт хэрэг, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам, цагдаагийн байгууллагын ажиллагаа, ард иргэдтэй харьцах ажиллагааны талаар мэдээлж байх хэрэгтэй. Харин хэрэг бүртгэх, мөрдөн байцаах үйл ажиллагаа гэж асар том зүйл байна л даа. Тэр үйл ажиллагаанд хэн ч орохгүй, ЦЕГ-ын дарга ч ордоггүй юм л даа. Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд зааснаар л үйл ажиллагаа явуулна. Үүн дээр ЦЕГ зөвхөн боловсон хүчний бодлого, сахилгын хариуцлага тооцох замаар л нөлөөлнө. Ялангуяа эрүүгийн эрэн сурвалжлах ажил байна. Хэрэг бүртгэх шатанд энэ хэрэг гарсан эсэхийг тогтооно. Мөрдөн байцаалтад хэн буруутайг тогтоох ажиллагаа явуулж, шүүхэд өгөхөд шүүх гэм буруутай эсэхийг нь тогтооно. Тиймээс хэрэг тогтоогдоогүй байхад мэдээлэл өгдөггүй юм. Гэтэл сэтгүүлчид хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын алба руу орох гээд дайраад байдаг” хэмээн учирлав.



Сэтгүүлчид, цагдаа хууль хяналтын байгууллагын энэхүү зөрчилдөөн нэг талаар сэтгүүлчдийн мэдээлэл авах, мэдсэнээ олон нийтэд түгээх эрх, нөгөө талаар хууль хяналтын байгууллагын хууль сахиулах, нийгмийн аюулгүй байдлыг хангах үүрэг мөргөлдөн зөрчилдөж буйгаас үүдэлтэй болов уу. Энэхүү зөрчилдөөн нь зөвхөн Монголд л тохиолдож буй зүйл биш. Гэмт хэрэг, шүүн таслах ажиллагааны талаар нийтэд мэдээлэх нь тухайн хэрэгт холбогдож буй хувь хүний эрхтэй шууд холбоотой туйлын ярвигтай, нарийн, эмзэг асуудал учир энэ талаар мэдээлэх нь олон нийтэд чухам ямар ач холбогдолтой байхыг сайтар тунгаан бодож байх нь чухал болов уу. Хөгжингүй улс оронд гэмт хэрэг, шүүн таслах үйл явцын талаар мэдээлэл түгээхийг хууль, дүрэм, ёс зүйн журмаар нарийн зохицуулсан байдаг бол манайд энэхүү эрх зүйн орчин нь дутагдаж байж ч болох юм. Нөгөө талаар, хэвлэлийн эрх чөлөөнд ч тодорхой хязгаар байдгийг ойлгож, хүлээн зөвшөөрөх хүртэл нэлээд хугацаа шаардлагатай бололтой.

Хууль хяналтын байгууллагын хатуу чанга байдлыг хүлээн зөвшөөрдөг сэтгүүлчдээс Монголын Үндэсний радиогийн сэтгүүлч Эрдэнэчимэг, мөн ТВ-5 телевизийн ерөнхий редактор Дагиймааг дурьдаж болно. Дагиймаа МУИС-ын сэтгүүл зүйн ангийг төгсөөд хэвлэл мэдээллийн салбарт 8 дахь жилдээ ажиллаж байгаа бөгөөд, сэтгүүлчээр ажиллах хугацааныхаа нэлээдийг хууль зүйн чиглэлээр дагнан ажилласан. Тэрээр Монголд Хүний Эрхийн комиссоос зохион байгуулсан эрүүгийн шүүхийн тухай нэвтрүүлгийн уралдаанд “Албадан саатуулахад өнгөрөөсөн 3 хоног” нэвтрүүлгээрээ оролцож, тэргүүн байр эзэлж байсан аж. “Хүний эрх зөрчиж байгаа тухай цагдаагийн байгууллагад сурвалжлага хийгээд явахад цагдаагийн байгууллага хаалттай байсан уу гэвэл үгүй. Би тэгэхэд цагдаагийн байгууллагын онц хүнд гэмт хэргийн тасгийнх нь даргын тухай нэвтрүүлэг хийж байсан. Шүүхийн шийдвэр биелүүлэх ерөнхий газар ч нээлттэй байсан.” Түүний бодлоор, сэтгүүлч хүн мэдээллийг авч чадаж л байвал бүх зүйл нээлттэй байна. “Мэдээж хэрэг асуудал нь шийдэгдээгүй, тушаал гараагүй, эсхүл үндэсний аюулгүй байдалтай холбоотой зэрэг нууц гэж байна шүү дээ, тэр бол хуулийнхаа хүрээнд зөв байдаг байх. Гэхдээ сэтгүүлч гэдэг чинь угаасаа овсгоотой байх ёстой, мэдээллийг олж авах ёстой, тэрэнд эх сурвалж байх ёстой, тэр эх сурвалжаа ашиглаж чаддаг байх ёстой. Түүнээс биш зарим хүмүүс хэвлэлийн эрх чөлөө боогдмол гээд л ярьдаг, би тэрний эсрэг байр суурьтай байна. Хаалттай байдаг юм бол өнөөдөр яагаад бүх сонин дээр Тагнуулын ерөнхий газрын тухай мэдээ гардаг юм. Үнэхээр таг нуудаг байсан бол гарахгүй шүү дээ. Тэгэхлээр өнөөдөр манайд эх сурвалжаа хэн олж авсан нь тэр мэдээллийг хамгийн түрүүнд тавьж байгаа.”

Улсын Ерөнхий Прокурорын Газрын хэвлэл мэдээллийн албаны ажилтан П.Тунгалаг Дагиймаагийн санааг батлан хэлэхдээ, “Прокурорын байгууллагын тухай хуулинд юу юуг нууц гэж хэлэх вэ гэдгийг заасан байдаг. Харин нууцын зэрэглэлтэй мэдээллийг хөндсөн, тийм мэдээлэл авъя гэж сэтгүүлчид над дээр ирж байгаагүй. Над руу утасдаад, радиогоос ярьж байна, Үнэн сониноос ярьж байна, танайхаар сонин юу байна гэж асууна. Өөдөөс нь сонин юм байхгүй ээ

гэхээр тэгсхийгээд л орхичихно. Юм гарвал өгөөрэй л гэнэ. Сэтгүүлчид өөрсдөө ийм үхээнц байдлыг бий болгож байгаа. Гэтэл зарим сэтгүүлч, жишээ нь “Зууны мэдээ” сонины сурвалжлагчид өөр, илүү мэрийлттэй байдаг, өөрөө хэлтсийнхэнтэй холбоо тогтоогоод, танайхаар юу байна, юу бүтэж байна, яах ёстой юм гээд, хөөцөлдөж байгаад мэдээллийг олж авдаг. Магад бусад хүмүүс “Зууны мэдээ”-г хувьсгалт намын талынх болохоор прокурор мэдээлэл өгөөд байна гэж боддог байх. Үгүй дээ, “Зууны мэдээ” сонины сурвалжлагчид илүү сайн эрэн сурвалжилдаг, өөрсдийгөө дайчилдаг, мэрийлттэй ажилладаг, мэдээллийг авах гэж тэмүүлдэг учир тэдний сонинд прокурорын тухай илүү мэдээлэл гардаг” гэж ярьсан юм. Тунгалаг өөрөө сэтгүүлч мэргэжилтэй, хэвлэл мэдээллийн салбарт 15 жил ажилласан учир сэтгүүлчдийн эрэлт хэрэгцээ, хүндрэл бэрхшээлийг сайн мэдэж, ойлгодог. Тэрээр хүнд суртал сэтгүүлчдийн ажилд үнэхээр их хүндрэл учруулдаг гэдгийг мэддэг, хүлээн зөвшөөрдөг. “Үнэхээр хууль хяналтын байгууллагууд хүнд сурталтай байдаг. Танил талын шугамаар л мэдээлэл олж авахгүй бол бас хэцүү, үүнтэй санал нийлнэ. Хүнд суртал бол ганц прокурор ч биш, ганц шүүх цагдаа ч биш, Монгол улсын бүх төрийн байгууллагууд хүнд сурталтай. 70-80 жил явсан социализмын үлдэгдэл байдаг байлгүй” гэж Тунгалаг яриад, “би өөрөө сэтгүүлч хүний хувьд мэргэжил нэгтнүүддээ мэдээллийг чөлөөтэй өгөх эрмэлзэлтэй байдаг, гэвч байгууллагын дүрэм, журманд захирагдан, мэдээллийг бодлоготой өгөх асуудал гардаг” хэмээсэн. Цагдаа, хуулийн бусад байгууллагын адил прокурорын газар хэвлэл мэдээллийн албаны журмыг мөрддөг аж. Тэр журмын дагуу тухайн байгууллагатай холбоотой мэдээллийг зөвхөн нэг газраас, өөрөөр хэлбэл хэвлэл мэдээллийн албанаас өгнө. Дурын нэг албан тушаалтан шууд мэдээлэл өгөх эрхгүй. Хэвлэл мэдээллийн ажилтан нь сэтгүүлчдийн хүссэн мэдээллийг дур мэдээд өгчихгүй, хэлтсийн даргатай зөвшилцөж ярилцсаны үндсэн дээр гаргадаг гэнэ. Энэ нь тухайн байгууллагын болон сэтгүүлчдийн ажил үүргийн хооронд зөрчил үүсгэдэг, магадгүй үүнээс болж сэтгүүлчид халширдаг ч байж болох юм хэмээн Тунгалаг ярихдаа, “гэхдээ л манай сэтгүүлчдийн ур чадвар ер нь тааруухан шүү дээ” хэмээн гунигтайхан хэлж байв. Үүнд сэтгүүлчдийг дангаар нь буруутгах үндэслэлгүй гэж бас тэднийг өмөөрч ч үзнэ. “Сэтгүүлчдэд ажиллах нөхцлийг байгууллагын зүгээс гаргах боломж муу байдаг. Жишээ нь прокурорын газраас нийслэлийн хорих газруудаар шалгалт хийсэн тухай албаны модон хэллэгээр бичсэн хэвлэлийн мэдээлэл тараалаа гэж бодъё. Тэр дотроос сэтгүүлч хүн өөрөө нэг юм уу хоёр өгүүлбэр сугалж аваад, үүнийг л би дэлгэрүүлээд сурвалжлая гээд явах ёстой. Гэтэл тэд нөгөө нэг нүүр хэвлэлийн мэдээг тэр чигээр нь аваачаад нийтэлчихдэг байхгүй юу. Учир нь хэн нэг нь жишээ нь Авдрантын хорих газар луу яваад ирье гэхэд тэр хүнд унаа ч олдохгүй, томилолтын мөнгө ч олдохгүй, тэгж байтал аягүй бол дараагийн дугаарын хариуцлагатай жижүүрээр ажиллах болоод, ажлаа хаяад ч явж болдоггүй тийм нөхцөл байдал үүсдэг” гэв.

ХБНГУ-д мөрдөн байцаалт, шүүх үйл явц зэрэг төрийн байгууллагаас хууль сахиулах, хувь хүний болон нийтийн эрх ашгийн үүднээс зохион байгуулж буй үйл ажиллагааны эцсийн үр дүн гараагүй байх үед мэдээлэл түгээснээр уг үйл явцыг удаашруулах, саад болохоор бол уг мэдээллийг үйл явц дуустал сэтгүүлчдэд өгөхөөс түдгэлзэж болно хэмээн холбооны улсуудын хэвлэлийн хуулинд заасан байдаг. Гэхдээ тухайн мэдээллийг түгээснээр мөрдөн байцаалтад, эсхүл шүүхийн ажилд үнэхээр саад учирч болзошгүй байгаа эсэхийг нягталж байж, тухайн байгууллага мэдээлэл өгч болохгүй гэсэн шийдийг гаргах үүрэгтэй. /U. Branahl, Medienrecht, 2.Auflage, 1997, Westdeutscher Verlag GmbH, Opladen, p.38/

### **Сэтгүүлчдийн мэдээлэл авах эрхийг хуульчлах хэрэгтэй юу?**

“Хэрэгтэй” хэмээн сэтгүүлч Баатархуяг эрс шийдэмгийн хэлсэн юм. Тэрээр “Мэдээлэл авах эрх гэдэг чинь сэтгүүлчдийн эрх ашгийн төлөө биш, олон нийтийн эрх ашиг шүү дээ. Олон нийт мэдээлэл авах эрхтэй, бид түүнийг нь дамжуулах үүрэгтэй. Сэтгүүлчид энэ талаар гомдол гаргадаг, түүнийг нь шийддэг байгууллага байх хэрэгтэй. Мэдээлэл өгөөгүй тохиолдолд тухайн албан тушаалтантай хэрхэн хариуцлага тооцох тухай заалт байх хэрэгтэй” гэж үзэж байв. Энэхүү үзэл бодлыг зарим сэтгүүлчид дэмжиж, зарим нь үгүйсгэж, үлдсэн нь “хууль байгаад ч нэмэргүй” хэмээн гутрах аж. “Сэрүүлэг” сонины ерөнхий редактор Цоожчулуунцэцэг “Хүн хэвлэн нийтлэх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөтэй гээд хуулинд заачихсан байдаг. Гэтэл мэдээлэл авах эрхийг баталгаажуулаагүй, сэтгүүлчид мэдээлэл авч чадахгүй болохоор энэ эрх чөлөө чинь эргээд хаалттай болчихож байгаа байхгүй юу. Олон түмнийг мэдээллээр хангаж өгөхийн тулд, мэдээлэл авах эрхийг чөлөөтэй болгохын тулд тодорхой зохицуулалт хэрэгтэй байна” хэмээн үзэж байв, Энэ үзэл бодлыг Өдрийн сонины Алтантуяа, ТВ 9-ийн Эрдэнэцогт, Үнэн сонины Бүдээхүү, чөлөөт сэтгүүлч Цондовдорж, Өнөөдөр сонины Заяабат зэрэг олон сэтгүүлч дэмжиж байсан. Төрийн статустай мэдээллийн байгууллагад ажилладаг, тиймээс мэдээлэл авахад харьцангуй хялбар байдаг хэмээн ярьсан ММ агентлагийн Отгонбаатар ч мөн адил, иймэрхүү хууль байх шаардлагатай хэмээн үзэж байв. Учир нь мэдээлэл түгээхдээ ММ агентлаг, Үндэсний Телевизийг онцолж, бусдыг нь ангилж ялгадаг, гэтэл хэвлэл мэдээллийнхэн эрх тэгш байх ёстой, энэ утгаараа мэдээлэл авах эрхийг хуульчилж хамгаалах ёстой гэж тэр хэлсэн юм.

Дашрамд дурьдахад, Хууль Зүй, Дотоод Хэргийн сайдын 2001 оны 22-р тоот тушаалын хавсралтын дагуу, тухайн яам, харъяа агентлагийн ажилтнууд хариуцсан ажлынхаа талаар байгууллага болон хувийн нууцаас бусад тохиолдолд 3-5 хоногийн дотор тодорхой хариулт өгч байх ёстой аж. Хууль гарахыг хүлээлгүй сайд дарга нар тухайн байгууллагынхаа хүнд суртлыг багасгах, сэтгүүлчдэд нээлттэй байлгах тал дээр анхаардагсан бол энэ нь сэтгүүлчид ажил үүргээ гүйцэтгэхэд хичнээн тус болохсон бол. Гагцхүү дээр дурдсан тогтоолын талаар сэтгүүлчид сайн

мэдэх агаад, энэхүү тогтоол нь хэрэгждэггүй гэдгийг ч мөн сайн мэддэг аж. Хэвлэлийн эрх чөлөөний хууль 1998 онд батлагдаад, одоог болтол бүрэн хэрэгжихгүй, төрийн статустай мэдээллийн хэрэгсэл байсаар байгааг ч бидний уулзсан сэтгүүлчид ярьж л байлаа. “Монголын хууль гурав хоног гэдэг. Хууль хэрэгжүүлэх нь тулгамдсан асуудал болоод байна” гэж Финляндын сэтгүүлч Иръя Халаш ярьж байхад, мэргэжил нэгт монгол нөхөд ч үүнтэй санал нэг байв. Байгаа хууль дүрмээ хэрэгжүүлээд, дээрээс нь сэтгүүлчид мэргэжлийн ёс зүйн зарчмаа баримтлаад явах л юм бол Монголын сэтгүүл зүй хөгжинө хэмээн үзэх сэтгүүлч цөөнгүй байхад, сэтгүүлч Цэрэн-Очирын хэлсэнчлэн “ хуульчилсан ч хуульчлаагүй ч ялгаагүй. Тогтолцоо нь ийм байгаагаас хойш” хэмээн үзэж буй сэтгүүлч ч бас байна.

Үргэлжлэл бий

Жич: “Монгол дахь мэдээллийн эрх чөлөө” номны үргэлжлэлийг Хэвлэлийн Хүрээлэнгийн Мэдээлэл судалгааны албанаас авч үзнэ үү.